



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.3, 30.2, 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар баталсан "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцүүлэн шинэчлэн боловсруулсан Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн Бага насны хүүхдийн танхимын хөтөлбөрийг нэгдүгээр, Анхан шатны тусламж үзүүлэх танхимын хөтөлбөрийг хоёрдугаар, Газар хөдлөлтийн чинирхийллийг биеэр мэдрүүлэх танхимын хөтөлбөрийг гуравдугаар, Гал унтраах сургалт, дадлагын танхимын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Угаат орчноос аврах ажиллагааны танхимын хөтөлбөрийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгийн аюулыг биеэр мэдрүүлэх, гамшгаас хамгаалах дадал, чадвар олгох сургалтыг хөтөлбөрийн дагуу 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж явуулахыг Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв (хурандаа Г.Хүрэлбаатар)-д, сургалтын явц, үр дүнд тогтмол хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлос)-д даалгасугай.

ДАРГА,

ХУРАНДАА

Ж.ЧУЛТЭМСҮРЭН

